



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ЭМХЭТГЭЛ

2017

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН

ХӨГЖЛИЙН 2017 ОНЫ СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА



Хүн ам

Аймгийн хүн амын тоо 2017 оны жилийн эцсийн байдлаар 115684 болж, өмнөх оныхоос 1773 хүнээр буюу 1.5 хувиар өсчээ. Нийт хүн амын 30.2 хувийг 15 хүртэлх насны хүүхэд, 65.4 хувийг 15-64 насныхан, 4.4 хувийг 65 түүнээс дээш насныхан эзэлж байна. Өмнөх онтой харьцуулахад 15 хүртэлх насны хүн амын эзлэх хувь 0.4 пунктээр, 65 түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь 0.6 пунктээр өсч, 15-64 насны хүн амын эзлэх хувь 1.0 пунктээр буурчээ.

Нийт хүн амын 49.8 хувь нь эрэгтэйчүүд, 50.2 хувь нь эмэгтэйчүүд байна. Хүйсийн харьцаа буюу 100 эмэгтэйд ноогдох эрэгтэйчүүдийн тоо 99.1 байна.

Шинээр төрсөн 2505 хүүхдийг иргэний бүртгэлд бүртгэн, нас барсан 701 хүнийг иргэний бүртгэлээс хасч, 536 хос гэрлэлтээ бүртгүүлж, 54 гэр бүлийн гэрлэлтийг цуцалж, 75 хүүхэд үрчлэгдсэн байна.

2017 онд 968 хүн шилжиж явснаас 77.8 хувь буюу 505 хүн УБ хотруу шилжин явсан байна. Тус аймагт 1078 хүн шилжин ирсний 62.0 хувь буюу 669 хүн УБ хотоос, 38.0 хувь буюу 409 хүн бусад аймгуудаас шилжин ирсэн байна.

Аймгийн нийт өрх 34150 болж, өнгөрсөн оноос 1.8 хувь буюу 610 өрхөөр нэмэгдсэн байна. Нийт өрхийн 24.6 хувь нь аймгийн төвд, 30.8 хувь нь сумын төвд, 44.6 хувь нь хөдөөд суурьшсан байна. Нийт өрхийн 19.0 хувь нь нэг ам бүлтэй, 15.6 хувь нь 2 ам бүлтэй, 16.8 хувь нь 3 ам бүлтэй, 21.5 хувь нь 4 ам бүлтэй, 15.6 хувь нь 5 ам бүлтэй, 11.5 хувь нь 6 ба түүнээс дээш ам бүлтэй байна. Нийт өрхийн 5.1 хувь нь 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх байгаа ба ихэр хүүхэдтэй 290 өрх байна.

Хөгжлийн бэрхшээлтэй 3870 хүн байгаагийн 42.7 хувь нь эмэгтэй байна. Аймгийн хэмжээгээр 2017 онд өнчин хүүхдийн тоо 1773 болж, нийт хүүхдийн 5.1 хувийг эзэлж байна. Нийт өнчин хүүхдийн 5.9 хувь буюу 105 хүүхэд нь бүтэн өнчин, 94.1 хувь буюу 1668 нь хагас өнчин хүүхдүүд байна. Аймгийн хэмжээнд 2017 оны байдлаар өрх толгойлсон эмэгтэй 3730 байгаагийн 30.3 хувь нь аймгийн төвд, 69.7 хувь нь хөдөө сумдад амьдарч байна.



Бүртгэлтэй ажилгүй иргэн

Аймгийн нийт хүн амын 63.0 хувь буюу 72837 нь хөдөлмөрийн насны хүн ам байгаа нь өмнөх оныхоос 604 хүнээр буюу 0.8 хувиар өссөн байна. Аймгийн хэмжээнд 1559 шинэ ажлын байр бий болсоны 8.1 хувь нь барилгад, 18.1 хувь нь хөдөө аж ахуйд, 32.1 хувь нь боловсруулах үйлдвэрлэлд, 8.7 хувь нь бөөний болон жижиглэн худалдаанд, 0.2 хувь нь тээвэр холбоонд, 6.5 хувь нь боловсролын байгууллагад, 26.3 хувь нь хувийн үйлчилгээ эрхлэх чиглэлээр ажлын байртай болжээ.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт 1160 хүн ажил хайж бүртгүүлсний 60.1 хувь нь эмэгтэйчүүд байна. Бүртгүүлсэн ажилгүйчүүдийн тоог өнгөрсөн оныхтой

харьцуулахад 53.3 хувиар буурсан байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 31.4 хувь нь 25-34 насныхан, 23.2 хувь нь 35-44 насныхан, 26.8 хувь нь 16-24 насныхан, 18.6 хувь нь 45-аас дээш насныхан байна.



Нийгмийн халамж, даатгал

Аймгийн дүнгээр давхардсан тоогоор 39.7 мянган хүнд 11.9 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон байна. Үүнд 2359 хүнд 2.6 тэрбум төгрөгийн халамжийн тэтгэвэр, 2364 хүнд 1.4 тэрбум төгрөгийн нөхцөлт мөнгөн тэтгэмж, нийгмийн халамжийн тусламж дэмжлэг шаардлагатай 2331 хүнд 1.2 тэрбум төгрөгийн тэтгэмж, тусламж, 10078 ахмад настанд 1.1 тэрбум төгрөг, алдарт эхийн одонтой 10076 хүнд 1.4 тэрбум төгрөг, 1316 хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 0.3 тэрбум төгрөгийн тусламж, хөнгөлөлтийг тус тус олгожээ.

Нийгмийн даатгалын сангийн орлого 61.5 тэрбум төгрөг болж өнгөрсөн оноос 7.0 хувиар өссөн байна. Нийт 26673 хүн даатгалд хамрагдсаны 51.4 хувь буюу 13720 нь заавал даатгуулагчид, 48.6 хувь буюу 12953 нь сайн дурын даатгуулагчид байна. Даатгалын сангийн орлогын 80.3 хувь нь тэтгэврийн даатгалын сан, 3.2 хувь нь тэтгэмжийн даатгалын сан, 2.2 хувь нь ҮОМШӨ-ний даатгалын сан, 13.6 хувь нь эрүүл мэндийн даатгалын сан, 0.8 хувь нь ажилгүйдлийн даатгалын сан тус тус эзэлж байна.



Боловсрол, соёл

Ерөнхий боловсролын сургууль 2008-2009 оны хичээлийн жилээс 12 жилийн тогтолцоонд шилжиж, 6 настай хүүхдийг нэгдүгээр ангид элсүүлэх болсноор 5 хүртэлх насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулж байна.

2017-2018 онд нийт 41 цэцэрлэгийн 266 бүлэгт 6562 хүүхэд хүмүүжиж байгаа нь өмнөх оныхоос 296 хүүхдээр буюу 4.7 хувиар өссөн байна.

Сургуулийн өмнөх боловсролд хамрагдвал зохих (2-5 насны) хүүхдийн 83.1 хувь нь буюу 9076 хүүхэд хамрагдсан нь өмнөх оны хамрагдалтаас 5.8 хувиар буурсан байна.

2017-2018 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 30 сургуулийн 793 бүлэгт 21517 хүүхэд өдрөөр суралцаж байна. Ерөнхий боловсролын сургуулийн багшийн тоо 2017 онд 1145 байгаагийн 34.9 хувь нь бага ангийн, 38.5 хувь нь дунд ангийн, 26.6 хувь нь ахлах ангийн багш байна.



Эрүүл мэнд

2017 онд 2417 эх амаржиж 2428 хүүхэд төрсөн нь өмнөх оноос 247 хүүхдээр буюу 9.2 хувиар буурчээ. Эмнэлэгт 601 хүн нас барсны 6.5 хувийг 1 хүртлэх насны хүүхэд, 1.7 хувийг 1-5 хүртэл насны хүүхэд эзэлж байна.

Нэг хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоо 2017 онд 39 болж 2016 оныхоос 16 хүүхдээр буюу 29.0 хувиар, 1-5 хүртлэх насандаа эндсэн хүүхэд 10 байгаа нь өмнөх оныхоос 11 хүүхдээр буюу 52.4 хувиар тус тус буурсан байна.

2017 онд халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 1114 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 1088 хүнээр буюу 2.0 дахин буурсан байна. Нийт өвчлөлийн 35.4 хувь нь салхин цэцэг, 22.0 хувийг тэмбүү, 12.1 хувийг цусан суулга, 9.7 хувийг трихоминиаз, 7.5 хувийг заг хүйтэн, 5.9 хувийг сүрьеэ, 0.4 хувийг вируст гепатит эзэлж байна.

Халдварт өвчлөлийг өмнөх оныхтой харьцуулбал салхин цэцэг 17.5 хувиар, трихоминиаз 2.8 дахин, тэмбүү 46.4 хувиар, заг хүйтэн 29.2 хувиар, цусан суулга 3.3 дахин өсч, вируст гепатит 3.2 дахин буурсан байна.



Гэмт хэрэг

Цагдаагийн газрын мэдээгээр 2017 онд аймгийн хэмжээнд 492 гэмт хэрэг гарсан нь өмнөх оныхоос 16 гэмт хэргээр буюу 3.1 хувиар буурсан байна. Энэ онд гарсан гэмт хэргийн 174 нь буюу 35.3 хувь нь аймгийн төвд үйлдэгджээ.

Нийт гэмт хэргийн дотор өндөр хувийн жин эзэлдэг хэргүүдийг авч үзвэл: Хулгайн хэрэг 2017 онд 212 гарсан нь нийт хэргийн 43.0 хувийг эзэлж, өмнөх оныхоос 8 хэргээр буюу 3.9 хувиар өссөн байна. Хулгайн хэрэг дотроо хувийн өмчийн хулгай энэ онд 146 гарсан нь өмнөх оныхоос 1.4 хувиар, авто тээврийн хэрэгслийн хулгай 5 хэргээр буюу 16.6 хувиар тус тус өссөн байна. Бусдын бие махбодид гэмтэл учруулсан хэрэг энэ онд 139 гарсан нь нийт хэргийн 28.2 хувийг эзэлж байна.

2017 онд гарсан гэмт хэргийг 425 хүн үйлдсэний 29 хүн буюу 6.8 хувь нь хүүхэд, 244 хүн буюу 57.4 хувь нь 18-34 насны залуучууд, 107 хүн буюу 25.1 хувь нь 35-аас дээш насныхан үйлджээ. Мөн нийгмийн байдлаар нь авч үзвэл: Хамгийн өндөр буюу 40.7 хувийг ажилгүй иргэд, 34.6 хувийг малчин иргэд, 8.7 хувийг хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд, 6.1 хувийг оюутан сурагч, 8.2 хувийг албан хаагч үйлдсэн байна. Нийт хэрэг үйлдэгчдийн 108 хүн буюу 25.4 хувь нь согтуудаа үйлдсэн байна.

Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 1084.3 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оныхоос 112.8 сая төгрөг буюу 11.6 хувиар өссөн байна. Нийт учирсан хохирлын 572.8 сая төгрөг буюу 52.8 хувийг нөхөн төлүүлжээ. Гэмт хэргийн улмаас 193 хүн гэмтэж, 30 хүн нас барсан нь өмнөх оныхоос гэмтсэн хүний тоо 20.9 хувиар, нас барсан хүний тоо 9.0 хувиар тус тус буурчээ.



Байгаль орчин

Өвөрхангай аймаг нь Монгол улсын төв хэсэгт Архангай, Булган, Баянхонгор, Төв, Дундговь, Өмнөговь аймгуудтай хиллэдэг. Газар зүйн байрлалаар далайн түвшнээс 1813 метрт өргөгдсөн, 102 градус 47 минутын уртраг 46 градус 16 минутын өргөрөгт, хойноос урагшаа 385 км, зүүнээс баруун хил хүртэл 310 км үргэлжилнэ.

Аймгийн нутаг дэвсгэрийг газрын нэгдмэл сангийн ангиллаар авч үзэхэд 2017 онд нийт нутгийн 90.5 хувийг хөдөө аж ахуйн газар, 5.8 хувийг улсын тусгай хэрэгцээний газар, 2.4 хувийг ойн сан бүхий газар, 0.1 хувийг усан сан бүхий газар, 0.7

хувийг хот тосгон бусад суурин газар, 0.4 хувийг зам шугам сүлжээний газар эзэлж байна.



Хөрөнгө оруулалт

2017 онд аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд 23.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийснээс 33.0 хувь буюу 7.9 тэрбум төгрөг нь улсын төсвийн хөрөнгө, 14.2 хувь буюу 3.4 тэрбум төгрөг нь орон нутгийн төсөв болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр, 24.2 хувь буюу 5.8 тэрбум төгрөг нь гадаадын хөрөнгө оруулалт, 28.3 хувь буюу 6.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт нь иргэдийн хөрөнгөөр тус тус санхүүжигдсэн байна. 2016 онтой харьцуулахад хөрөнгө оруулалтын хэмжээ 11.2 хувь буюу 3.0 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хөрөнгө оруулалтын ажлын 38.6 хувийг барилга угсралт, их засварын ажилд 27.4 хувийг зам засвар арчлалтад, 0.2 хувийг худаг шинээр гаргах болон засварлах, 2.6 хувийг гэрэлтүүлэг, гадна байгууламжийн тохижилт, шинэчлэлийн ажил болон дулааны шугам засварт, 30.7 хувийг машин, тоног төхөөрөмж, эд хогшил нийлүүлэхэд, 0.5 хувийг бусад ажилд тус тус зарцуулсан байна.



Банк, мөнгө, зээл

Манай аймагт 2017 онд арилжааны 5 банкны салбар аж ахуйн нэгж, байгууллага иргэдэд үйлчилгээ үзүүлээ. Арилжааны банкуудын дүнгээр 35562 зээлдэгчид байгаа нь өнгөрсөн оноос зээлдэгчдийн тооноос 6.0 хувиар өсч, олгосон зээлийн хэмжээ 27.4 хувиар буурчээ. 2017 онд нийт 110.0 тэрбум төгрөгийн зээл олгосон байна. Оны эцэст зээлийн өрийн үлдэгдэл 168.9 тэрбум төгрөг байгаа ба хугацаа хэтэрсэн зээл 1.7 хувь буюу 2840.7 сая.төгрөг, чанаргүй зээл 1.2 хувь буюу 2109.6 сая.төгрөг байна.

Иргэд, байгууллагын мөнгөн хадгаламж 109.9 тэрбум төгрөг болж өнгөрсөн оныхоос 24.6 хувь буюу 21.7 тэрбум төгрөгөөр өсч, аймгийн нэг хүнд дунджаар 949.9 мянган төгрөгийн, нэг хадгаламж эзэмшигчид 1429.9 мян.төгрөгийн хадгаламж ногдож байна. Өнгөрсөн оноос хадгаламж эзэмшигчийн тоо 0.3 хувиар буурсан байна.



Төсөв санхүү

Улсын төсвийн дэмжлэгийг оруулан тооцсоноор аймгийн нэгдсэн төсөвт 2017 онд 14.3 тэрбум төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөний биелэлт 97.4 хувьтай байна. Орон нутгийн орлогын 70.3 хувийг татварын орлого, 29.7 хувийг татварын бус орлого эзэлж байна.

Улс болон орон нутгийн төсвөөс 73.8 тэрбум төгрөгийн санхүүжилт хийсэн ба 72.9 хувийг ажил, үйлчилгээний зардал, 0.2 хувийг татаас, 22.0 хувийг урсгал шилжүүлэг, 5.7 хувийг хөрөнгийн зардал тус тус эзэлж байна. Бараа, ажил, үйлчилгээний зардлын 63.5 хувийг цалинд, 7.0 хувийг нийгмийн даатгалын шимтгэлд, 10.5 хувийг байр ашиглалтай холбоотой зардалд, 2.5 хувийг бараа материалын зардалд, 6.3 хувийг нормативт зардалд, 1.9 хувийг урсгал засварт, 0.4 хувийг

томилолтын зардалд, 3.3 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажилд, 4.6 хувийг бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулжээ.



Үнэ

2017 оны эцсийн байдлаар аймгийн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тарифын индекс 2016 оныхтой харьцуулахад 2.2 хувиар өссөн байна.

Барааны бүлгээр нь авч үзвэл хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн индекс 3.1 хувиар, согтууруулах ундаа, тамхины бүлгийн индекс 4.1 хувиар, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн индекс 4.1 хувиар, тээврийн үйлчилгээний бүлгийн индекс 9.3 хувиар, эм тариа, эмнэлэгийн үйлчилгээний бүлгийн индекс 1.2 хувиар, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийн индекс 0.3 хувиар, амралт чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлгийн индекс 3.5 хувиар, зочид буудал, нийтийн хоолны үйлчилгээний бүлгийн индекс 0.2 хувиар, бусад бараа үйлчилгээний бүлгийн индекс 0.6 хувиар тус тус өссөн байна. Харин хувцас, бөс бараа, гуталны бүлгийн индекс 1.4 хувиар, орон сууц, ус, цахилгаан, хийн бусад үйлчилгээний бүлгийн индекс 1.8 хувиар тус тус буурсан байна. Өдөр тутмын өргөн хэрэглээний барааны нэр төрлөөр авч үзвэл өмнөх оны мөн үеийнхээс талх, гурил будааны дундаж үнэ 0.5 хувиар, мах махан бүтээгдэхүүний дундаж үнэ 1.5 хувиар буурчээ. Хүнсний ногооны дундаж үнэ 30.2 хувиар, жимс жимсгэний дундаж үнэ 4.4 хувиар, барилгын бараа материал 3.2 хувиар, цахилгааны үнэ 7.5 хувиар нэмэгдсэн байна.



Хөдөө аж ахуй

2017 оны жилийн эцсийн тооллогын дүнгээр малын тоо 5743.5 мянган толгойд хүрч, 534.9 мянган толгойгоор өссөн ба төрлөөр авч үзвэл тэмээ 28.8 мянга, адуу 364.0 мянга, үхэр 298.2 мянга, хонь 2663.3 мянга, ямаа 2389.2 мянга болж, тэмээ 9.5 хувь буюу 2.5 мянган толгой, адуу 12.6 хувь буюу 40.7 мянган толгой, үхэр 14.7 хувь буюу 38.3 мянган толгой, хонь 10.0 хувь буюу 284.8 мянган толгой, ямаа 7.6 хувь буюу 168.7 мянган толгойгоор тус тус өссөн байна.

Нийт мал сүргийн дотор тэмээ 0.5 хувь, адуу 6.3 хувь, үхэр 5.2 хувь, хонь 46.4 хувь, ямаа 41.6 хувийг тус тус эзэлж, нийт сүрэгт 5 төрлийн малын эзлэх хувь өмнөх оныхоос ямаан сүргийн хувьд 1.0 пунктээр буурч, хонин сүргийн эзлэх хувь 0.7 пунктээр, үхэр сүргийн эзлэх хувь 0.2 пунктээр, адуун сүргийн эзлэх хувь 0.1 пунктээр тус тус нэмэгдэж, тэмээ сүргийн эзлэх хувьд өөрчлөлт ороогүй байна.

Малтай өрх 18956 байгаа ба үүний 84.9 хувь буюу 16087 нь малчин өрх байна. Эдгээр өрхийн тоо 2016 оныхоос малтай өрх 2.4 хувиар буюу 436 өрхөөр, малчин өрх 4.4 хувиар буюу 680 өрхөөр тус тус нэмэгдсэн байна. Малчдын тоо 28265 болж өмнөх оноос 5.8 хувиар буюу 1728-аар буурсан байна. Нийт малчдын 35.7 хувь нь 16-34 насны, 50.4 хувь нь 35-59 насны, 13.6 хувь нь 60 болон түүнээс дээш насны малчид байна. Аймгийн нэг малтай өрхөд 303 толгой мал, нэг малчин өрхөд 357 толгой мал ноогдож байна.

Малын тоо аймгийн 19 сумдад өссөн ба Төгрөг суманд хамгийн өндөр буюу 20.9 хувиар өссөн байна. Сант суманд 20.3 хувиар, Бат-Өлзий, Баянгол, Есөнзүйл, Өлзийт, Зүүнбаян-Улаан, Богд, Тарагт, Хужирт суманд 10.3-17.6 хувь, бусад суманд 10 хүртэл хувиар тус тус өссөн байна.

Аймгийн хэмжээнд Богд сум 454.7 мянган толгой малаар тэргүүлж, Баянгол сум 426.1 мянган толгойгоор удаалж, Баян-Өндөр сум 412.1 мянган толгой малаар гуравдугаарт, Бүрд сум 364.4 мянган толгой малаар дөрөвдүгээрт, Уянга сум 350.0 мянган толгой малаар тавдугаарт орж байна. Таван төрлийн мал тус бүрийн дүнгээр 9.8 мянган толгой тэмээгээр Богд, 34.1 мянган толгой адуугаар Хужирт, 60.6 мянган толгой үхрээр Уянга, 230.1 мянган толгой хониор, 315.2 мянган толгой ямаагаар Богд сум тус тус тэргүүлж байна.

Аймгийн 109 баг дотор нийт малын тоогоор Баянгол сумын Өнц баг 120.6 мянган толгой малаар нэгдүгээрт, Бүрд сумын Аржаргалант баг 106.9 мянган толгой малаар хоёрдугаарт, Бат-Өлзий сумын Улаан-Ам 104.8 мянган толгой малаар гуравдугаарт, Баян-Өндөр сумын Батхаан баг баг 102.3 мянган малаар дөрөвдүгээрт, Баянгол сумын Цавын-Ихэр баг 97.1 мянган толгой малаар тавдугаарт тус тус орж байна. Төрөл тус бүрээр 3.7 мянган толгой тэмээгээр Богд сумын Далан, 9.6 мянган толгой адуугаар Өлзийт сумын Борхошуу, 20.9 мянган толгой үхрээр Бат-өлзий сумын Улаан-Ам, 66.7 мянган толгой хониор Баянгол сумын Өнц, 68.3 мянган толгой ямаагаар Богд сумын Далан багууд тус тус тэргүүлж байна.

Аймгийн хэмжээнд нийт малаараа Сант сумын Царги багийн малчин өрх 3909 толгой мал тоолуулж аймагтаа тэргүүлсэн байна. Хамгийн олон тэмээтэй өрх Баруунбаян-Улаан сумын Цагаан-Овоо багт, хамгийн олон адуутай өрх Хархорин сумын Шанх багт, хамгийн олон үхэртэй өрх Бат-Өлзий сумын Улаан-Ам багт, хамгийн олон хоньтой өрх Сант сумын Царги багт, хамгийн олон ямаатай өрх Богд сумын Ховд багт байна.

1000 ба түүнээс дээш малтай 941 өрх байгаа нь өмнөх оныхоос 20.8 хувь буюу 162-р нэмэгдсэн байна. Бүрд сум 108 мянгат малчны тоогоор тэргүүлж, Баянгол сум 104 мянгат малчинтайгаар хоёрдугаарт, Баян-Өндөр сум 100 мянгат малчинтайгаар гуравдугаарт орж байна. Аймгийн хэмжээнд 2000 аас дээш мал тоолуулсан 57 өрх байгаагийн 10 өрх нь Бүрд суманд, 9 өрх нь Баянгол суманд байна.

Нийт малтай өрхийн 1.7 хувь буюу 319 нь 10 хүртэл малтай, 5.3 хувь буюу 1008 өрх 11-30 хүртэл малтай, 6.4 хувь буюу 1208 өрх 31-50 хүртэл малтай, 12.8 хувь буюу 2422 өрх нь 51-100 хүртэл малтай, 22.5 хувь буюу 4273 өрх 101-200 малтай, 34.2 хувь буюу 6475 өрх 201-500 малтай, 12.2 хувь буюу 2310 өрх 501-999 малтай, 4.0 хувь буюу 762 өрх 1000-1499 малтай, 0.6 хувь буюу 122 өрх 1500-2000 малтай, 0.3 хувь буюу 57 өрх 2000-аас дээш малтай байна. Малтай өрхийн бүлэглэлт тус бүрийн нийт малтай өрхөд эзлэх хувийг өмнөх онтой харьцуулахад 10 хүртэл малтай өрхийн нийт малтай өрхөд эзлэх хувь 0.3 пунктээр, 11-30 хүртэл малтай өрхийнх 0.9 пунктээр, 31-50 хүртэл малтай өрхийнх 0.5 пунктээр, 51-100 хүртэл малтай өрхийнх 0.8 пунктээр, 101-200 хүртэл малтай өрхийнх 0.7 пунктээр тус тус буурсан бол 201-500 хүртэл малтай өрхийнх 1.2 пунктээр, 501-999 хүртэл малтай өрхийнх 1.2 пунктээр, 1000-1499 хүртэл малтай өрхийнх 0.6 пунктээр, 1500-2000 малтай өрхийнх 0.1 пунктээр, 2000-аас дээш малтай өрхийнх 0.1 пунктээр тус тус өссөн байна.

Оны эхний малын 16.3 хувь буюу 847.8 мянган толгой малыг зах зээлд худалдан борлуулж, 6.6 хувь буюу 341.2 мянган толгой малыг хүнсэнд хэрэглэж, 7.3 хувь буюу 380.5 мянган толгой малыг бусдад шилжүүлсэн байна.

Нийт 2285.5 мянган хээлтэгч мал тоологдсон нь нийт малын 39.8 хувийг эзэлж, өнгөрсөн оноос хээлтэгчийн тоо 9.2 хувиар буюу 192.6 мянган толгойгоор өсч, нийт малд эзлэх хувийн жин урд оноос 0.4 пунктээр буурсан байна.

Оны эхний төллөх эх малын 93.5 хувь буюу 1955.9 мянган эх мал төллөж, гарсан төлийн 96.6 хувь буюу 1890.5 мянган төлийг бойжуулсан байна.

Оны эхэнд тоологдсон нийт малын 0.6 хувь буюу 29.3 мянган толгой мал зүй бусаар хорогдсон ба хорогдлын 94.0 хувийг бог мал эзэлж байна. Хорогдсон малын 8.3 хувь буюу 2440 толгой нь өвчнөөр хорогдсон байна.

Нийт 41281 толгой хээлтүүлэгчийн 62.8 хувийг хуц, ухна эзэлж байна. Нэг хээлтүүлэгчид 5 төрөл дээр 34 ингэ, 10 гүү, 29 үнээ, 79 эм хонь, 81 эм ямаа ногдож байгаа нь үржлийн нормт хэмжээнээс ингэ, гүү, үнээ нормын түвшинд, эм хонь, эм ямаа нормоос өндөр байна.

Аймгийн хэмжээнд нийт 23 аж ахуйн нэгж байгууллагууд 5970 толгой мал тоолуулсан байна.

Цэвэр, эрлийз, нутгийн шилмэл омгийн 341.2 мянган мал тоологдсоны 26. хувь буюу 88.6 мянган толгой нь цэвэр үүлдэр, 74.0 хувь буюу 252.5 мянган толгой нь эрлийз мал байна. Урд оноос цэвэр, эрлийз, нутгийн шилмэл омгийн мал 16.4 хувь буюу 66.8 мянган толгойгоор буурсан байна. Нийт эрлийз малын 41.7 хувь нь хээлтэгч, 1.0 хувь нь хээлтүүлэгч мал байна.

Малжуулалтын талаар авсан арга хэмжээний тайлангаар аймгийн хэмжээнд нийт 13 сумын 115 өрхөд 5526 толгой мал малжуулах төсөл, хөтөлбөрөөр олгогдсон байна. Малжуулалтад хамрагдсан нэг өрхөд дунджаар 48 толгой мал ноогдож байна.

Тэжээвэр амьтад аймгийн дүнгээр 281 гахай, 542 нь тахиа, 152 бүл зөгий тоологдсон байна. Аймгийн хэмжээнд мал аж ахуйн салбарт 2017 онд шинээр 15 худаг гаргаж, 36 худаг засварласан байна.

Аймгийн хэмжээнд 8217.5 га-д үр тариа тариалсан ба үүний 8102.5 га-д буудай, 5.0 га-д арвай, 110 га-д овъёос тариалжээ. Үр тариа тариалалт өмнөх оноос 2513.8 га-р илүү хийгдсэн байна. Энэ онд 395.1 га-д төмс, 213.6 га-д хүнсний ногоо тариалсан нь өмнөх онтой харьцуулахад төмс 20.0 га-гаар, хүнсний ногоо 7.7 га-гаар илүү тариалсан байна.

Ургац хураалтын эцсийн мэдээгээр 2094 тн буудай, 4 тн арвай, 15 тн овъёос, 3917.6 тн төмс, 2020.0 тн хүнсний ногоо, 1.5 мянган тн малын тэжээл, 102 тн рапс хураан аваад байна.

Малчдын өөрсдийн бэлтгэсэн хадлан 14.6 мянган тн, гаднаас худалдаж авсан нь 18.0 мянган тн байна. Нийт бэлтгэсэн хадлан нь өмнөх оны мөн үеээс 2.5 мянган тн-оор бага байна. Гар тэжээл 7.1 мянган тн-ийг бэлтгэсэн нь өмнөх оны мөн үеээс 1.9 мянган тн-оор илүү байна.



Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлт оны үнээр 2017 онд 37.6 тэрбум төгрөгт хүрч, 2016 оныхоос 3.4 тэрбум төгрөг буюу 9.8 хувиар өссөн байна. Нийт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний 29.9 хувь нь уул уурхайн салбарт, 53.5 хувь нь боловсруулах аж үйлдвэрийн салбарт, 16.6 хувь нь дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамжийн салбарт үйлдвэрлэгдсэн байна. Бүтээгдэхүүний нэр төрлийн хувьд нүүрс, талх, бялуу, цэвэр ус рашаан, сүү, сүүн бүтээгдэхүүн, архи, бууз банш, гутал, оёмол бүтээгдэхүүн, угаасан ноос түгээсэн ус, сувагжуулалт, дулааны эрчим хүч, тоосго үйлдвэрлэл 2.2-38.9 хувиар өссөн байна. Харин нарийн боов, хэрчсэн гурил, хиам, гэрийн мод, барилгын материалын үйлдвэрлэлт 1.3-18.7 хувиар буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн оны үнээр 37.0 тэрбум төгрөгт хүрч, үүнээс уул уурхай, олборлох аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн 30.4 хувь буюу 11.2 тэрбум төгрөг, боловсруулах аж үйлдвэрийн салбарынх 52.7 хувь буюу 19.5 тэрбум төгрөг, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамжийн салбарынх 16.9 хувь буюу 6.3 тэрбум төгрөгт хүрсэн байна.



Тээвэр, холбоо

Бүх төрлийн авто тээврээр 2017 онд 56.7 мян.тн ачаа, давхардсан тоогоор 313.3 мянган хүн тээвэрлэж, ачаа эргэлт 19062.5 мян.тн км, зорчигч эргэлт 87720.9 мян хүн км болж нэмэгдсэн байна. Тээсэн ачаа 2016 оныхоос 12.1 хувь буюу 6.1 мянган тонноор, зорчигчдын тоо 11.4 хувь буюу 32.1 мянган хүнээр тус тус өслөө. Тээврийн үйлчилгээний орлого 2848.1 сая.төгрөгт хүрч өмнөх оноос 316.5 сая төгрөг буюу 12.5 хувиар өссөн байна.

Сүүлийн жилүүдэд үүрэн утасны хэрэглэгчдийн тоо нэмэгдэж, давхардсан тоогоор 93.9 мянган хэрэглэгчтэй болсон өмнөх оныхоос 0.8 мянган хэрэглэгчээр буюу 0.8 хувиар өссөн байна.

Суурин утасны цэгийн тоо 663 болж өмнөх оноос 73-аар буурсан байна. Кабелийн телевизийн хэрэглэгчдийн тоо 3980 болж өмнөх оноос 96 хэрэглэгчээр нэмэгдсэн байна.

Холбооны байгууллагууд 645.5 сая төгрөгийн орлоготой ажилласны 29.9 хувь нь хүн амын үйлчилгээний орлого байна. Өнгөрсөн оноос нийт орлого 1.2 хувиар буюу 7.6 сая.төгрөгөөр буурчээ. Холбооны интернетээр үйлчлүүлэгчдийн тоо 9165 болж 228.7 сая.төгрөгийн орлоготой ажилласан байна.



Барилга

Барилгын гүйцэтгэгч байгууллагууд 9.2 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажлыг хийж гүйцэтгэсний 6.6 хувь буюу 0.9 тэрбум төгрөг нь их засварын ажил байна. Өмнөх оныхоос гүйцэтгэсэн барилга угсралтын ажлын хэмжээ 10.8

тэрбум төгрөгөөр буюу 2.2 дахин, их засварын ажил 264.8 сая төгрөгөөр буюу 30.0 хувиар тус тус буурсан байна.

Автозам засвар арчлалтын байгууллагууд 6.5 тэрбум төгрөгийн ажлыг 12 объектод хийсэн ба өнгөрсөн оныхтой харьцуулахад 3.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.



Орон сууц, нийтийн аж ахуй

2017 онд аж ахуйн нэгж, иргэдийн хөрөнгөөр нийт 3340 м.кв талбай бүхий 51 айлын нийтийн зориулалттай орон сууц, 17443.4 м.кв талбай бүхий 209 айлын сууцны тусдаа байшин ашиглалтанд орсон байна. Ус түгээх байрны тоо 2017 онд 98 болж, зөөврийн ус хэрэглэдэг өрхийн тоо 19.3 мянгад хүрч, өмнөх оныхоос 1.9 хувиар нэмэгдсэн байна. Аймгийн хэмжээнд 2017 онд 175 хүний багтаамжтай 37 халуун усны цэг үйл ажиллагаа явуулж байна.



Аж ахуйн нэгж байгууллага

Аймгийн татварын албанд бүртгэлтэй аж ахуйн нэгжийн тоо 2017 оны жилийн эцсийн байдлаар 1851 байна. Хариуцлагын хэлбэрээр нь авч үзвэл төсөвт байгууллага 207, ХК 10, ХХК 871, салбарууд 108, хоршоо 190, ЗБН 41, ББН 57, төрийн бус байгууллага 295, ОНБайгууллага 20, хадгаламж зээлийн хоршоо 7, шашны байгууллага 14 байна.

Татварт бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын тоо өмнөх оноос 7.1 хувь буюу 123-аар нэмэгдсэн байна. Тухайлбал ХХКомпаниуд 72, төрийн бус байгууллагууд 40, ББН 1, хоршоо 8, сан 1, шашны байгууллага 2, салбар 5-аар тус тус нэмэгдсэн байна.

АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

1	Үзүүлэлт	х/н	2014	2015	2016	2017
1	Газрын сан	га	6289.5	6289.5	6289.5	6289.5
2	ХАА-н эдэлбэр газар	га	5719.7	5695.5	5694.5	5694.5
3	Өрх	тоо	33015	33275	33540	34150
4	Бүх хүн ам	тоо	112591	112774	113911	115684
5	Хөдөлмөрийн насны хүн ам	тоо	70500	71939	72233	72837
6	Төрсөн хүүхэд	тоо	2757	2755	2675	2505
7	Нас барсан хүн	тоо	601	621	659	701
8	Шилжин ирсэн хүн	тоо	760	849	1095	1078
9	Шилжин явсан хүн	тоо	3108	2639	2362	968
12	Хэрэглээний үнийн индекс /өмнөх оны мөн үетэй харьцуулснаар/	хувь	127.6	107	100.8	102.2
13	Орон нутгийн төсвий орлого	сая.төг	9015.8	10949.7	9046.3	14301.9*
14	Төсвийн зарлагын санхүүжилт	сая.төг	72182.6	66437.6	69881.5	73752.3*
15	Олгосон зээл	сая.төг	154888.5	149828.1	151516.5	110009.7
16	Хадгаламж	сая.төг	59742.1	61781.3	88182.6	109892.1
17	Хөрөнгө оруулалт	тэрбум.төг	70.0	40.0	26.9	23.9
	Үүнээс барилга угсралт, их засварын ажил	тэрбум.төг	51.1	28.2	20.3	9.2
18	Ашиглалтад оруулсан орон сууц	өрх	480	459	180	260
19	Малын тоо	толгой	4111515	4510986	5208582	5743530
	Тэмээ	толгой	21970	23128	26251	28756
	Адуу	толгой	246950	280197	323363	364015
	Үхэр	толгой	183265	217599	259939	298244
	Хонь	толгой	1821050	2021762	2378488	2663296
	Ямаа	толгой	1838280	1968300	2220541	2389219
20	Бойжсон төл	толгой	1137219	1440601	1678524	1890452
21	Тариалсан талбай	га	3022.1	4602.1	6284.7	8826.2
22	Хураасан ургац	тонн	10203.4	10648.5	15122.5	8050.6
23	Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая.төг	30547.8	32369.2	34245.9	37601.9*
24	Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн борлуулалт	сая.төг	29980.7	31904.0	33873.7	36996.3*
25	ЕБ-ийн сургуульд суралцагсад	тоо	20634	21200	21199	21517
26	Бүх шатны сургуулийн багш нар	тоо	1284	1338	1306	1145
27	Бүртгэлтэй аж ахуйн нэгж байгууллага	тоо	1533	1628	1728	1851
28	Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	492	542	508	492

Тайлбар: * 2017 оны урьдчилсан байдлаар гарав.

БҮЛЭГ 1**ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ, НУТАГ ДЭВСГЭР****1.1 ЗАСАГ ЗАХИРГААНЫ
НЭГЖ****1.1 ADMINISTRATIVE UNITS**

СУМДЫН НЭР	Багийн тоо	Нутаг дэвсгэр км.кв	Хүн амын нягтшил
БҮГД	109	62895	1.8
Баян-Өндөр	5	3248	1.2
Бүрд	5	2581	1.1
Бат-Өлзий	5	2428	3.1
Баруунбаян-Улаан	4	3941	0.7
Баянгол	6	3543	1.1
Гучин-Ус	4	4753	0.5
Есөнзүйл	4	2211	1.4
Өлзийт	4	1797	1.4
Зүүнбаян-Улаан	6	2701	1.5
Богд	7	10155	0.6
Нарийнтээл	4	2702	1.4
Сант	5	2564	1.4
Тарагт	6	3395	1.0
Төгрөг	5	5467	0.5
Уянга	8	3139	3.0
Хайрхандулаан	6	4138	0.9
Хужирт	6	1718	3.9
Хархорин	8	2241	5.6
Арвайхээр	11	173	182.0

1.2 АЙМГИЙН ТӨВӨӨС СУМЫН ТӨВ ХҮРТЭЛХ ЗАЙ**1.2 DISTANCE BETWEEN AIMAG AND COM CENTER**

Сумдын нэр	Сумын төв	Хоорондох зай /км/
Баян-Өндөр	Бумбат	122
Бүрд	Онгон	136
Бат-Өлзий	Өвт	124
Баруунбаян-Улаан	Хөөвөр	175
Баянгол	Ширээ	80
Гучин-Ус	Аргуйт	104
Есөнзүйл	Мөнхбулаг	100
Өлзийт	Агуйт	88
Зүүнбаян-Улаан	Баян-Улаан	47
Богд	Ховд	197
Нарийнтээл	Цагаан-Овоо	135
Сант	Майхан	100
Тарагт	Хүрэмт	35
Төгрөг	Хоолт	95
Уянга	Онги	61
Хайрхандулаан	Марзат	72
Хужирт	Шунхлай	84
Хархорин	Вангийн-Овоо	138

**БҮЛЭГ 1
ДЭВСГЭР**

ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ, НУТАГ

1.3 СУМ ХООРОНДЫН ЗАМЬ

1.3 DISTANCE BETWEEN THE SOUMS, km

Сумдын нэр	Сант	Баянгол	Төгрөг	Баян-Өндөр	Есөнзүйл	Бүрд	Хужирт	Хархорин	Зүүнбаян-Улаан	Бат-Өлзий	Тарагт	Уянга	Хайрхандулаан	Нарийнтээл	Баруунбаян-Улаан	Гучин-Ус	Богд	Арвайхээр	Улаанбаатар
Арвайхээр																			431
Богд																		201	631
Гучин-Ус																100	101	531	
Баруунбаян-Улаан															89	99	174	605	
Нарийнтээл														123	104	222	134	565	
Хайрхандулаан													64	116	87	187	73	504	
Уянга												68	97	184	159	259	58	489	
Тарагт											24	95	121	196	123	223	34	465	
Бат-Өлзий										90	66	135	165	249	199	299	98	433	
Зүүнбаян-Улаан									52	50	26	94	123	220	147	247	46	439	
Хархорин								106	100	156	132	200	229	311	252	298	137	360	
Хужирт							51	55	49	105	81	159	182	260	187	287	86	384	
Бүрд						108	123	165	157	164	188	203	264	304	231	331	130	332	
Есөнзүйл					36	64	115	121	113	128	152	167	228	268	195	295	94	366	
Баян-Өндөр				73	109	137	246	155	207	143	167	182	237	283	197	297	109	330	
Төгрөг			149	181	217	173	224	133	185	121	145	135	152	138	48	148	87	517	
Баянгол		49	100	168	204	160	211	120	172	108	132	147	201	186	97	197	74	505	
Сант		46	95	54	113	222	178	229	138	190	126	150	165	225	232	143	243	92	384
Өлзийт	97	163	176	50	23	95	85	136	135	134	123	147	162	223	263	190	290	89	387


БҮЛЭГ 2

ХҮН АМ

2.1 ХҮН АМ, байршилаар
2.1 POPULATION , by location

Сумын нэр	Бүх хүн ам			Бүх хүн амаас		Өрх бүгд	үүнээс	
	бүгд	эр	эм	Сумын төвд	хөдөөд		сумын төвд	хөдөөд
БҮГД	115684	57588	58096	64310	51374	34150	18925	15225
Баян-Өндөр	3816	1907	1909	749	3067	1169	246	923
Бүрд	2951	1515	1436	767	2184	858	211	647
Бат-Өлзий	7499	3728	3771	4374	3125	2229	1255	974
Баруунбаян-Улаан	2803	1403	1400	963	1840	718	239	479
Баянгол	3939	1978	1961	1018	2921	1174	329	845
Гучин-Ус	2195	1102	1093	676	1519	637	216	421
Есөнзүйл	3115	1599	1516	916	2199	929	260	669
Өлзийт	2446	1243	1203	1002	1444	766	316	450
Зүүнбаян-Улаан	4066	2089	1977	823	3243	1302	258	1044
Богд	5626	2853	2773	1583	4043	1484	391	1093
Нарийнтээл	3663	1857	1806	831	2832	1060	284	776
Сант	3644	1858	1786	781	2863	1041	252	789
Тарагт	3373	1731	1642	806	2567	1094	279	815
Төгрөг	2764	1393	1371	1126	1638	824	345	479
Уянга	9512	4762	4750	5020	4492	2834	1489	1345
Хайрхандулаан	3518	1790	1728	888	2630	1114	254	860
Хужирт	6751	3415	3336	3609	3142	1992	1091	901
Хархорин	12516	6246	6270	8958	3558	3828	2814	1014
Арвайхээр	31487	15119	16368	29420	2067	9097	8396	701

Өзгч агуу өнөөд, аооддөөд



2.2 СУУРИН ХҮН АМЫН ТОО, насны бүлгээр
2.2 RESIDENT POPULATION, by age group

Насны бүлэг	2014			2015			2016			2017		
	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм
Бүгд	112591	56052	56539	112774	56197	56577	113911	56713	57198	115684	57588	58096
0-4	12673	6405	6268	12958	6694	6264	13311	6768	6543	13422	6874	6548
5-9	10577	5452	5125	11180	5757	5423	11712	6060	5652	12142	6221	5921
10-14	9569	4894	4675	9188	4669	4519	9019	4585	4434	9329	4770	4559
15-19	10990	5611	5379	10733	5522	5211	10530	5404	5126	10153	5155	4998
20-24	10852	5505	5347	10291	5298	4993	10002	5184	4818	10099	5303	4796
25-29	10116	5106	5010	10053	5126	4927	9993	5145	4848	9986	5129	4857
30-34	8733	4447	4286	8745	4406	4339	9012	4539	4473	9131	4592	4539
35-39	8347	4148	4199	8263	4141	4122	8261	4180	4081	8331	4212	4119
40-44	7672	3788	3884	7678	3786	3892	7742	3788	3954	7817	3831	3986
45-49	6603	3206	3397	6697	3178	3519	6791	3256	3535	6928	3335	3593
50-54	5497	2664	2833	5506	2650	2856	5776	2740	3036	5885	2824	3061
55-59	3693	1690	2003	4061	1828	2233	4126	1878	2248	4507	2065	2442
60-64	2448	1120	1328	2473	1109	1364	2695	1168	1527	2844	1204	1640
65-69	1528	626	902	1653	699	954	1676	713	963	1821	781	1040
70+	3293	1390	1903	3295	1334	1961	3265	1305	1960	3289	1292	1997

БҮЛЭГ 2

2.3 СУУРИН ХҮН АМЫН ТОО, насны бүлгээр, сумдаар

2.3 RESIDENT POPULATION, by age group and soms

	Баян-Өндөр			Бүрд			Бат-Өлзий			Баруунбаян-Улаан			Баянгол			Гучин-Ус			Есөнзүйл			Өлзийт			Зүүнбаян-Улаан			Богд	
	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	
Бүгд	3816	1907	1909	2951	1515	1436	7499	3728	3771	2803	1403	1400	3939	1978	1961	2195	1102	1093	3115	1599	1516	2446	1243	1203	4066	2089	1977	5626	
0-4	413	197	216	287	154	133	929	474	455	378	192	186	394	200	194	232	119	113	355	193	162	282	137	145	507	267	240	714	
5-9	395	198	197	312	162	150	857	402	455	308	156	152	380	182	198	238	114	124	301	163	138	242	138	104	377	183	194	650	
10-14	304	155	149	250	115	135	657	337	320	215	105	110	335	178	157	168	92	76	271	130	141	196	95	101	324	158	166	490	
15-19	343	182	161	254	133	121	692	360	332	300	153	147	389	185	204	241	126	115	281	152	129	208	102	106	328	163	165	573	
20-24	333	177	156	281	154	127	571	310	261	279	135	144	376	208	168	223	124	99	303	163	140	185	101	84	339	182	157	577	
25-29	267	139	128	231	133	98	704	339	365	234	122	112	295	158	137	181	99	82	250	137	113	200	114	86	381	203	178	468	
30-34	327	162	165	221	110	111	609	313	296	207	123	84	267	141	126	159	80	79	215	102	113	171	87	84	341	188	153	409	
35-39	277	155	122	218	114	104	520	257	263	188	87	101	309	161	148	160	82	78	227	119	108	197	100	97	292	167	125	416	
40-44	258	127	131	206	101	105	505	268	237	162	80	82	285	145	140	150	69	81	202	101	101	169	78	91	270	144	126	351	
45-49	234	119	115	173	89	84	458	211	247	150	72	78	271	128	143	122	58	64	180	94	86	142	71	71	239	118	121	298	
50-54	185	92	93	145	77	68	371	176	195	141	72	69	219	121	98	97	43	54	149	75	74	123	64	59	217	100	117	252	
55-59	145	70	75	117	55	62	263	123	140	93	42	51	168	80	88	86	43	43	132	66	66	98	52	46	185	89	96	165	
60-64	116	45	71	86	44	42	144	67	77	55	20	35	95	37	58	59	25	34	74	23	51	67	21	46	104	48	56	103	
65-69	65	25	40	64	30	34	82	32	50	32	17	15	60	28	32	32	11	21	67	33	34	65	29	36	78	41	37	50	
70+	154	64	90	106	44	62	137	59	78	61	27	34	96	26	70	47	17	30	108	48	60	101	54	47	84	38	46	110	
	Богд		Нарийнтээл			Сант			Тарагт			Төгрөг			Уянга			Хайрхандулаан			Хужирт			Хархорин			Арвайхээр		
	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм
Бүгд	2853	2773	3663	1857	1806	3644	1858	1786	3373	1731	1642	2764	1393	1371	9512	4762	4750	3518	1790	1728	6751	3415	3336	12516	6246	6270	31487	15119	16368
0-4	385	329	393	205	188	389	207	182	360	166	194	333	166	167	1109	569	540	403	196	207	709	378	331	1392	712	680	3843	1957	1886
5-9	352	298	357	177	180	351	197	154	331	174	157	283	155	128	972	517	455	327	179	148	734	375	359	1250	642	608	3477	1755	1722
10-14	246	244	277	150	127	333	176	157	258	126	132	233	114	119	886	446	440	293	155	138	581	304	277	877	455	422	2381	1233	1148
15-19	295	278	337	173	164	375	191	184	283	151	132	252	127	125	888	438	450	314	163	151	613	321	292	1007	514	493	2475	1226	1249
20-24	307	270	385	191	194	372	198	174	322	169	153	261	155	106	859	453	406	323	168	155	487	261	226	1091	568	523	2532	1279	1253
25-29	243	225	284	162	122	265	136	129	283	161	122	217	108	109	832	435	397	276	160	116	541	287	254	1085	566	519	2992	1427	1565
30-34	224	185	282	142	140	237	117	120	236	123	113	222	119	103	804	409	395	274	129	145	513	278	235	939	480	459	2698	1265	1433
35-39	199	217	264	138	126	269	148	121	253	139	114	197	96	101	739	394	345	269	145	124	485	247	238	854	427	427	2197	1037	1160
40-44	163	188	250	123	127	244	115	129	261	131	130	207	99	108	659	339	320	256	131	125	433	209	224	827	403	424	2122	1005	1117
45-49	136	162	233	119	114	223	107	116	208	114	94	169	83	86	526	246	280	240	128	112	415	207	208	807	388	419	1840	847	993
50-54	114	138	208	97	111	181	93	88	196	102	94	131	59	72	439	219	220	178	87	91	340	165	175	717	351	366	1596	717	879
55-59	78	87	175	84	91	146	62	84	141	64	77	99	47	52	317	126	191	120	43	77	318	145	173	570	268	302	1169	528	641
60-64	46	57	93	48	45	97	41	56	103	54	49	65	30	35	195	74	121	98	44	54	209	89	120	361	156	205	720	292	428
65-69	27	23	45	18	27	50	17	33	49	24	25	28	8	20	109	43	66	60	23	37	125	50	75	274	123	151	486	202	284
70+	38	72	80	30	50	112	53	59	89	33	56	67	27	40	178	54	124	87	39	48	248	99	149	465	193	272	959	349	610

БҮЛЭГ 2

2.4. ӨРХИЙН ТОО, ам бүлийн тоогоор

2.4 NUMBER OF HOUSEHOLD, by number of household members

Сумын нэр	БҮГД	Ам бүлийн тоогоор									
		1 ам бүлтэй	2 ам бүлтэй	3 ам бүлтэй	4 ам бүлтэй	5 ам бүлтэй	6 ам бүлтэй	7 ам бүлтэй	8 ам бүлтэй	9 ам бүлтэй	10,+ ам бүлтэй
Бүгд	34150	6491	5331	5746	7341	5330	2679	780	308	92	52
Баян-Өндөр	1169	254	185	181	245	191	91	13	9		
Бүрд	858	171	144	103	182	143	83	25	6	1	
Бат-Өлзий	2229	429	318	389	525	330	177	43	12	3	3
Баруунбаян-Улаан	718	126	79	85	133	124	98	43	17	9	4
Баянгол	1174	223	182	204	258	188	86	22	7	3	1
Гучин-Ус	637	126	95	101	123	101	63	19	7	1	1
Есөнзүйл	929	220	127	157	159	142	78	29	13	3	1
Өлзийт	766	189	114	117	144	134	47	12	6	3	
Зүүнбаян-Улаан	1302	322	200	212	279	185	80	20	4		
Богд	1484	230	176	235	299	267	175	62	29	7	4
Нарийнтээл	1060	199	152	173	226	190	76	28	13	2	1
Сант	1041	195	162	163	198	167	111	32	10	3	
Тарагт	1094	269	192	168	225	151	69	12	6	1	1
Төгрөг	824	166	123	147	158	133	70	17	7	3	
Уянга	2834	569	409	475	631	454	209	59	24	4	
Хайрхандулаан	1114	258	185	193	219	160	74	18	5	2	
Хужирт	1992	393	350	293	391	292	203	48	16	5	1
Хархорин	3828	757	680	657	779	564	268	75	32	10	6
Арвайхээр	9097	1395	1458	1693	2167	1414	621	203	85	32	29

2.5. 4 ТҮҮНЭЭС ДЭЭШ ХҮҮХЭДТЭЙ ӨРХИЙН ТОО, хүүхдийн тоогоор

2.5 NUMBER OF HOUSEHOLD WITH 4, over children by number of children

Сумын нэр	Бүгд	4 хүүхэдтэй	5 хүүхэдтэй	6 хүүхэдтэй	7 + хүүхэдтэй
Бүгд	1747	1376	271	72	28
Баян-Өндөр	38	38			
Бүрд	80	69	8	3	
Бат-Өлзий	131	85	25	15	6
Баруунбаян-Улаан	63	55	7	1	
Баянгол	65	50	12	3	
Гучин-Ус	32	27	4	1	
Зүйл	43	42	1		
Өлзийт	58	42	14	2	
Зүүнбаян-Улаан	42	29	12	1	
Богд	84	64	13	2	5
Нарийнтээл	42	33	9		
Сант	67	61	5	1	
Тарагт	38	33	3	2	
Төгрөг	52	36	13	3	
Уянга	108	94	13	1	
Хайрхандулаан	43	38	5		
Хужирт	125	96	24	5	
Хархорин	141	124	15	2	
Арвайхээр	495	360	88	30	17

2.6 БҮТЭН ӨНЧИН ХҮҮХДИЙН ТОО, сумдаар

2.6 NUMBER OF ORPHAN CHILDREN , by soms

	2013		2014		2015		2016		2017	
	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй
Бүгд	122	57	137	72	129	67	108	54	105	53
Баян-Өндөр	2	2	2	2	2	1	3	2	3	2
Бүрд	7	5	6	6	8	5	7	4	9	5
Бат-Өлзий	2	2	4	1	5	1	4	1	3	1
Баруунбаян-Улаан	1	1	1	1	1	1				
Баянгол	7	2	6	2	5	1	4	1	4	1
Гучин-Ус	3	1	1	1	1	1			1	1
Есөнзүйл	4	2	5	3	4	2	5	3	5	3
Өлзийт	2		3	1	2	1	2	1	2	1
Зүүнбаян-Улаан	5	2	8	3	6	3	3	1	2	1
Богд	2		2	1	4	1	7	1	7	1
Нарийнтээл	2	1	2	1	2	1	2	1		
Сант	5	2	4	1	5	1	3	1	2	1
Тарагт	6	3	3		2		1			
Төгрөг	6	3	6	3	4	3	4	4	2	2
Уянга	19	6	18	9	13	7	15	8	16	9
Хайрхандулаан	2	1	5	2	4	2	3	1	2	1
Хужирт	5	1	5	4	4	2	4	2	1	1
Хархорин	7	3	10	4	11	5	10	4	8	2
Арвайхээр	35	20	46	27	46	29	31	19	38	21

2.7 ХАГАС ӨНЧИН ХҮҮХДИЙН ТОО, сумдаар

2.7 NUMBER OF SINGLE PARENT CHILDREN , by soms

	2013		2014		2015		2016		2017	
	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй
Бүгд	1692	967	1639	804	1693	859	1638	783	1668	813
Баян-Өндөр	65	28	59	19	53	22	57	20	52	18
Бүрд	60	25	37	19	50	15	47	13	50	15
Бат-Өлзий	86	42	93	45	90	45	85	42	103	54
Баруунбаян-Улаан	37	11	43	14	37	13	45	14	44	12
Баянгол	48	26	36	16	39	13	46	20	47	19
Гучин-Ус	40	22	41	24	46	28	38	21	42	20
Есөнзүйл	54	24	56	26	56	28	47	19	47	23
Өлзийт	28	10	28	11	29	9	27	10	33	13
Зүүнбаян-Улаан	103	53	103	54	108	57	99	49	102	50
Богд	105	51	108	50	110	56	109	51	106	53
Нарийнтээл	59	27	62	31	62	34	57	30	52	28
Сант	75	36	76	39	68	32	58	32	59	28
Тарагт	52	23	54	22	50	24	47	22	56	28
Төгрөг	47	23	52	26	48	18	46	23	51	26
Уянга	151	73	123	65	194	98	196	100	176	86
Хайрхандулаан	54	34	54	32	51	28	45	21	52	24
Хужирт	105	62	71	42	82	54	105	63	108	68
Хархорин	135	126	171	79	191	92	150	65	164	83
Арвайхээр	388	271	372	190	329	193	334	168	324	165

2.8 ИХЭР ХҮҮХЭДТЭЙ ӨРХИЙН ТОО, ХҮҮХДИЙН ТОО

2.8 NUMBER OF HOUSEHOLD WITH TWIN, by number of children

	Өрхийн тоо			Хүүхдийн тоо		
	Бүгд	2 ихэр хүүхэдтэй	3 ихэр хүүхэдтэй	Бүгд	2 ихэр хүүхэд	3 ихэр хүүхэд
Бүгд	290	288	2	582	576	6
Баян-Өндөр	16	16		32	32	
Бүрд	10	10		20	20	
Бат-Өлзий	25	24	1	51	48	3
Баруунбаян-Улаан	3	3		6	6	
Баянгол	10	10		20	20	
Гучин-Ус	6	6		12	12	
Есөнзүйл	8	8		16	16	
Өлзийт	5	5		10	10	
Зүүнбаян-Улаан	3	3		6	6	
Богд	15	15		30	30	
Нарийнтээл	6	6		12	12	
Сант	8	8		16	16	
Тарагт	10	10		20	20	
Төгрөг	9	9		18	18	
Уянга	23	22	1	47	44	3
Хайрхандулаан	7	7		14	14	
Хужирт	15	15		30	30	
Хархорин	28	28		56	56	
Арвайхээр	83	83		166	166	

2.9 ЭМЭГТЭЙ ТЭРГҮҮЛЭГЧТЭЙ ӨРХИЙН ТОО

2.9 NUMBER OF FEMALE HEADED HOUSEHOLDS

	2012	2013	2014	2015	2016	2017
Бүгд	2930	3081	3867	3397	3469	3730
Баян-Өндөр	156	175	173	172	98	127
Бүрд	97	110	64	60	61	62
Бат-Өлзий	280	223	229	229	231	238
Баруунбаян-Улаан	76	69	90	80	81	62
Баянгол	78	53	67	64	27	30
Гучин-Ус	90	90	96	75	60	90
Есөнзүйл	97	145	149	154	166	169
Өлзийт	43	39	40	36	34	42
Зүүнбаян-Улаан	139	165	188	180	193	195
Богд	174	197	187	189	198	203
Нарийнтээл	96	84	99	87	93	89
Сант	68	82	103	82	95	81
Тарагт	89	92	117	119	118	93
төгрөг	91	98	86	90	144	140
Уянга	274	311	393	338	332	354
Хайрхандулаан	126	139	150	157	156	163
Хужирт	123	125	175	157	160	175
Хархорин	282	301	307	316	248	288
Арвайхээр	551	583	1154	812	974	1129

2.10 18 ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХЭДТЭЙ ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭЦЭГ/ЭХ/

2.10 SINGLE PEOPLE, WITH CHILDREN

Сумын нэр	2013	2014	2015	2016	2017
Бүгд	2257	2497	2211	2116	2271
Баян-Өндөр	51	45	45	48	45
Бүрд	30	30	28	27	29
Бат-Өлзий	398	391	392	373	385
Баруунбаян-Улаан	30	44	81	77	38
Баянгол	44	49	65	63	65
Гучин-Ус	35	7	10	58	35
Есөнзүйл	61	76	95	67	43
Өлзийт	21	34	24	24	26
Зүүнбаян-Улаан	46	41	36	48	42
Богд	68	156	175	183	190
Нарийнтээл	55	55	57	56	55
Сант	60	115	82	60	52
Тарагт	60	97	37	37	38
Төгрөг	81	74	81	83	82
Уянга	316	241	117	112	126
Хайрхандулаан	52	20	17	27	34
Хужирт	93	66	61	82	88
Хархорин	228	136	126	202	193
Арвайхээр	528	820	682	489	705

2.11. ӨНДӨР НАСТАЙ ГАНЦ БИЕ ӨРХИЙН ТОО, эм 55+, эр 60+

2.11 NUMBER OF HOUSEHOLD WITH SINGLE, women over 55, men over 60

Сумын нэр	2013	2014	2015	2016	2017
Бүгд	1538	2009	1980	2290	2278
Баян-Өндөр	103	83	87	78	107
Бүрд	66	67	61	63	66
Бат-Өлзий	133	131	133	139	147
Баруунбаян-Улаан	24	28	26	2	41
Баянгол	43	44	56	162	159
Гучин-Ус	25	40	23	34	36
Есөнзүйл	57	63	53	63	92
Өлзийт	55	51	49	45	43
Зүүнбаян-Улаан	48	53	55	50	50
Богд	72	67	77	82	83
Нарийнтээл	43	62	60	57	62
Сант	68	74	68	173	74
Тарагт	30	36	44	60	61
төгрөг	22	23	24	41	55
Уянга	142	175	195	189	196
Хайрхандулаан	47	54	51	67	66
Хужирт	123	176	212	201	193
Хархорин	124	213	248	287	232
Арвайхээр	313	569	458	497	515

БҮЛЭГ 2

2.12 ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО

2.12 NUMBER OF DISABLED, by soum

Сумын нэр	2014		2015		2016		2017	
	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй
Бүгд	3743	1736	3879	1794	3598	1551	3870	1651
Баян-Өндөр	148	67	139	63	142	61	146	63
Бүрд	84	36	86	38	71	30	70	30
Бат-Өлзий	215	84	215	83	217	84	237	87
Баруунбаян-Улаан	52	23	65	33	70	35	65	29
